


БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦАД НӨЛӨӨЛӨХ ИНБ-ЫН ОРОЛЦОО

Судалгааны товч танилцуулга



Танилцуулгыг боловсруулсан:

Д.Амаржаргал, ПИН Хөтөлбөр хариуцсан захирал

Б.Пүрэвбат, ПИН Мэдээлэл харилцааны ажилтан

СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр аливаа үйлчилгээг нийгэмд үзүүлэх, нөлөөллийн ажил зохион байгуулдаг тул нийгэмд чухал үүрэг гүйцэтгэж байдаг. ИНБ-ууд өөр хоорондоо бүтэц, арга барилын хувьд харилцан адилгүй ба дотооддоо болон олон улсад чиглэсэн өөр өөр түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг. Нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ууд нь засаглал, хэвлэл мэдээлэл, хөгжлийн салбарт идэвхтэй байдаг ба бодлого боловсруулалтад нөлөөлөх зорилготойгоор тодорхой асуудлуудад олон нийтийн төлөөллийн үүрэг гүйцэтгэж оролцдог. Энэхүү судалгаа нь Монгол Улсад ИНБ-уудын бодлого боловсруулалтад оролцох, бодлогын хэрэгжилтэд тавих хяналт ба төрийн байгууллагуудтай холбогдох харилцааг судлахад чиглэв.

Сүүлийн хорин жилийн хугацаанд Монгол Улсад олон чиглэлийн ИНБ-ууд байгуулагдсан хэдий ч хууль эрх зүйн орчин нь тэдний хөгжлийн хэрэгцээтэй хараахан дүйцэхгүй байна. 2022 оны байдлаар 35,312 ТББ-аас бүртгэлтэй гэж гарсан ч, үүнийг зөвхөн 6,380 нь л тогтмол үйл ажиллагаа явуулж байна. (Үндэсний Статистикийн хороо, 2023)

ИНБ-ууд санхүүжилт, хүний нөөц, менежментийн чадавхын хувьд хязгаарлагдмал нөхцөл байдалд орж байдаг ба энэ нь төр, ИНБ-ын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж улмаар хамтран ажиллахад тодорхой хүндрэл учруулж байдаг. Монголын ихэнх ИНБ-ууд бодлого боловсруулах үйл явцад шууд оролцох боломжоор хязгаарлагдмал байдаг. Гэвч энэ нь тухайн ИНБ-ын зорилго ба нийгэмд үзүүлэх үйлчилгээгээ хэрхэн тодорхойлсноос хамаарна.

ИНБ-ууд бодлого боловсруулах үйл явцад оролцохоос илүүтэй, төрийн бодлого, журмын хэрэгжилтэд хяналт тавихад илүүтэй оролцож байна. Цөөн тооны байгууллагууд бодлогын боловсруулалтад манлайлан оролцож чаддаг. Иргэний нийгмийн төлөөллүүд болон төрийн байгууллагын оролцогч талуудтай хийсэн ярилцлагын үеэр бодлого боловсруулахад идэвхтэй оролцох боломж, нөөц бололцоо бодитоор хомс байгаа талаар дурдсан. Хэдий тийм ч ИНБ-ууд бодлого боловсруулах явцад хяналт тавих замаар ийм яриа хэлэлцээрт идэвхтэй оролцох идэвх зүтгэл гаргасаар байна. Тэд тодорхой асуудлын талаар мэдээлэлтэй байж хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал хүсэлтээ өгөх, өргөдөл гаргахад нь олон нийтийг дэмжин ажилладаг. Засгийн газрын болон орон нутгийн удирдлагуудтай хамтран ИНБ-ууд бодлогын нөхцөл байдал, суурь нөхцөл, үр дагаврыг судалж, аливаа бодлого, зохицуулалтын талаар төрийн эрх баригчидтай байнга холбоотой ажиллахыг эрмэлздэг.

Түүнээс гадна ИНБ-уудын 80 гаруй хувь нь нийслэл хотод байршин үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийслэлийн байгууллагуудыг бодвол орон нутгийн ИНБ-уудад санхүүгийн боломж хязгаарлагдмал хэвээр байна.

2023 онд Civicus Монгол Улсыг "иргэний орон зай хумигдсан" гэж ангилсан бөгөөд зөвхөн өнгөрсөн нэг жилийн хугацаанд иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөө (FEI) олон удаа зөрчигдөж байсныг дурьджээ. Тухайлбал хуурамч мэдээлэл тараасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль эрх зүйн орчин бий болсноор иргэний нийгмийн ажилд саад учруулах талтай. Монголын ИНБ болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын эрхийг хуулиар хамгаалсан байдаг ч зарим талаараа дээр дурьдсан хуулийн зүйл заалт нь төр, хувийн хэвшил, нөлөө бүхий олон нийтийн зүтгэлтнүүдийн эсрэг шүүмжлэлийг дарж, ИНБ болон засгийн газрын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Европын холбоо, АНУ-ын засгийн газрын агентлагууд (ЭСЯ, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг), НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд (НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн сан, ХХААБ) зэрэг томоохон хандивлагч байгууллагуудын урт хугацааны санхүүжилт нь ИНБ-ыг дэмжихэд хүчтэй түлхэц үзүүлж байна. Тухайлбал Европын Холбооны монголын иргэний нийгмийн байгууллагуудтай 2021-2025 онд хамтран ажиллах хүрээ нь сайн жишээнүүдийн нэг юм. Пипл Ин Нийд ОУБТББ нь засгийн газар болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллах шинэлэг арга хэрэгсэл, механизмаар дамжуулан дотоодын ИНБ-ын оролцоог нэмэгдүүлэх системтэй арга барилыг боловсруулахаар санаачилга гарган ажиллаж байна.

Энэхүү судалгаагаар бид Засгийн газрын байгууллага, ИНБ болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, мөн одоогийн хамтын ажиллагаа, ИНБ-ын оролцооны механизмыг судлах зорилгоор чанарын болон тоон асуумж судалгааг авсан ба үүнд, баримт бичгийн судалгаа, ИНБ-уудаас авсан цахим асуумж судалгаа (40 ИНБ), үндсэн мэдээлэгчтэй хийсэн ярилцлага (9 төрийн албан тушаалтан, 9 ИНБ), фокус бүлгийн хэлэлцүүлгийн (11 ИНБ) аргуудыг ашигласан. Үүнээс гадна ИНБ ба засгийн газрын хамтын ажиллагааг илүү нээлттэй, шинэлэг, оролцоотой болгох зорилгоор цахим оролцооны арга хэрэгсэл, механизмыг сайжруулахад онцгой анхаарал хандуулсан.

Судалгааны үр дүнг ерөнхийд нь гурван үндсэн хэсэгт хуваасан.

- Төрийн байгууллага ба ИНБ хоорондын хамтын ажиллагааны талаарх одоогийн практик, туршлага
- ИНБ-уудад тулгарч буй саад бэрхшээл
- Бодлого боловсруулах үйл явцад нөлөөлөх ИНБ-ын оролцоог цаашид дэмжиж ажиллахад дөхөм болохуйц санаачлага

Уг судалганы тоймоор ИНБ-ын оролцоог бүхий л шатанд дэмжих зорилгоор ИНБ, Төрийн байгууллага, хандивлагч байгууллагуудад өгөх зөвлөмжийг, судалгааны үр дүнгийн хамт хураангуйлан оруулав.

СУДАЛГААНААС ГАРСАН ОНЦЛОХ ҮР ДҮН

Бодлого боловсруулах үйл явц ба ИНБ-ын оролцоо

ИНБ-ууд болон засгийн газрын оролцогч талууд бодлого боловсруулах үйл явцад иргэний нийгэм шууд оролцоход чадавхи, нөөцийн хувьд хязгаарлагдмал буюу хомс байгаа талаар дээр дурьдсан. Бодлогын түвшинд бичгээр санал хүсэлт өгөх, оролцох чадавхи, нөөц боломж нь байгууллага бүрд харилцан адилгүй байна. Бодлого боловсруулах явцад оролцох боломж хомс байгаа нь ИНБ-ууд үнэ цэнэтэй туршлага, судалгааны мэдээллээ бодлогын хэлэлцүүлэгт оруулах боломжийг бууруулахаас гадна нөгөө талаас ИНБ-уудыг судалгаа, дүн шинжилгээ хийхэд саад болох, шийдвэр гаргагчдыг чанартай мэдээллээр хангахыг хязгаарлаж байна.

ИНБ-уудын цөөхөн хувь нь тодорхой зорилготой, тогтсон хүний нөөцтэй, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, бодлого боловсруулах явцад оролцох чадавхитай. 2023 оны 1-р сард Пийпл Ин Нийд ОУТББ (ПИН)-аас 40 ИНБ-уудын дунд явуулсан цахим судалгааны үр дүнгээс харахад, оролцогч байгууллагуудын 40% нь ИНБ-ууд төрийн аливаа шийдвэрт нөлөөлөх чадвар муу гэж хариулсан байна. Түүнчлэн ИНБ-ын оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлгийн үеэр яам, тамгын газар зэрэг төрийн дээд шатны байгууллагууд ИНБ-уудтай хамтран ажиллах хүсэл эрмэлзэл бага байгааг онцолсон. Тэдэнд ИНБ-уудыг бодлогын түвшинд татан оролцуулах сонирхол бага байдаг. Дунд түвшиндээ хамтран ажиллах санаачилга гаргадаг боловч төрийн байгууллагууд ИНБ-ыг татан оролцуулах, тэднээс санал авах арга зүй дутмаг байдаг. Судалгаанд оролцогчдын дөнгөж 35% нь төрийн байгууллагуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагаа дунд түвшинд байна гэж хариулсан (онлайн судалгаанд оролцогчид). Бодлого боловсруулах явцад хэрхэн нөлөөлдөг талаар асуухад ИНБ-ын 83% нь бодлогын баримт бичгүүдэд санал бодлоо илэрхийлэх замаар бодлого боловсруулахад оролцдог гэсэн бол ердөө 10% нь нөлөөллийн лобби бүлэгт оролцдог, мөн бодлого боловсруулагч нартай тогтвортой харилцаатай байдаг гэсэн. Тухайлбал Алсын хараа 2050-г боловсруулахад ИНБ-ын консорциум оролцож, хууль боловсруулах явцад өгсөн саналыг тусгасан эсэх дээр эргэх холбоотой ажиллах тодорхой механизмыг засаглал хэсэгт тусгаж өгсөн. Мөн 2011 оны мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг бий болгоход нөлөөлж ажилласан гол байгууллага нь Глоб Интернэшнэл байв. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ гэр бүлийн тухай хууль болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг боловсруулахад олон жил зарцуулан голлох үүрэгтэй ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд гэхэд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль” боловсруулах, бас конвенцийг батлуулахад нөлөөлж ажилласан нь тэмдэглүүштэй.

Бодлого боловсруулах явцад болон бодлогын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох боломж ИНБ бүрд олдоод байдаггүй тул Монголын ихэнх ИНБ-ууд орон нутгийн болон улсын төсвийн зарцуулалтыг ажиглаж, сайн дураараа бодлогод хяналт тавих шаардлагатай болдог гэж ИНБ-ууд тэмдэглэв.

Бодлогын шинжилгээ, хяналтын оролцоо

Ярилцлагад оролцсон 9 ИНБ-ын 7 нь хууль эрх зүйн зохицуулалтанд хяналт тавих, төрийн тодорхой эрх бүхий байгууллагын гишүүдтэй шууд харилцах, зарим нэг төрийн байгууллагуудын дүрэм, журамд дүн шинжилгээ хийх чиглэлээр ажиллаж байна. Үүний тулд тэд эрх зүйн зохицуулалтын өнөөгийн төлөв байдлын талаар мэдээлэл авахын тулд төрийн байгууллагуудтай байнгын харилцаа холбоотой байдаг. Эдгээр байгууллагууд, жишээ нь, түүхий нүүрсний хоригийн тухай хууль тогтоомж зарим газарт яагаад хэрэгжихгүй байгаа, хэн хариуцлага хүлээх талаар тодорхой зохицуулалтын хэрэгжилтийн талаар ойлгож мэдэхийн тулд засгийн газрын эрх бүхий байгууллагуудтай уулзах, албан баримт бичгийг илгээх зэргээр ажилласан.

Нэмж дурдахад зарим ИНБ-ууд уур амьсгалын ногоон эрчим хүчний хөтөлбөр, залуучуудын боловсрол, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах зэрэг жижиг хэмжээний туршилтын төслүүдийг боловсруулж хэрэгжүүлэх, мөн залуучуудын оролцоо, хөгжилтэй холбоотой бодлогын яриа хэлэлцээр хийх чиглэлээр ажиллаж байна.

Үүнээс гадна ИНБ-ууд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар бодлогын зөвлөмж, санал хүсэлтийг гаргаж, олон нийтийн өргөдөл хүсэлтийг дэмжиж, иргэдийг арга хэмжээ авахыг уриалах зэргээр ажилладаг. Засгийн газрын зүгээс ч ИНБ-ууд болон иргэдэд бодлогын нөлөөлөл, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, мэдээллийг хүртээмжтэй авах, төсвийн өөрчлөлтийг дэмжих онлайн платформууд гаргасан. Эдгээр платформууд нь ИНБ, иргэдийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажилд санал, сэтгэгдлээ өгөхийг дэмжих, төсвийн зарцуулалтын талаар мэдээлэл өгөх, татан оролцуулах зорилготой. Тухайлбал, Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ) нь "Мэдээлэл, харилцаа холбооны операторуудын холбоо" ИНБ-тай хамтран үүрэн холбооны төлөөлөгчдийг нэгтгэх, технологийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, ИНБ-уудад зориулсан платформ боловсруулж гаргах, бодлогын түвшинд дуу хоолойг нь хүргэх чиглэлээр ажилладаг.

Төрийн зарим чиг үүргийг ИНБ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх

ИНБ-ууд болон төрийн оролцогч талуудтай хийсэн ярилцлагын үеэр төрийн байгууллагууд төрийн зарим чиг үүргийг ИНБ-аар гүйцэтгүүлж байгааг онцолсон. Нийгэмд үйлчлэх ИНБ-ууд бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэнд хяналт тавихаас гадна нийгмийн халамж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ зэргийг үзүүлдэг. Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газарт бүртгэлтэй, тэдний шаардлагыг хангасан ИНБ-ууд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх, техникийн болон мэргэжлийн ур чадвар олгох чиглэлээр гэрээ байгуулах тендерт оролцох боломжтой. Гэхдээ гэрээгээр гүйцэтгүүлэх нь энэ салбараар хязгаарлагддаг. Засгийн газар болон ИНБ-ын хамтын ажиллагаа нэмэгдэж байгаа ч үндэсний болон орон нутгийн түвшинд төрийн байгууллагуудын хамрах хүрээ, хамтын ажиллагааны түвшин харилцан адилгүй байна. Энэ нь төрийн албан хаагчдын орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог дэмжихэд ИНБ-ын гүйцэтгэх үүргийн талаарх ялгаатай үзэл бодлоос хамаарч байна.

Зарим ИНБ-ууд иргэдийн хэрэгцээг байнга тодорхойлж, үүссэн хэрэгцээнд шуурхай хариу үйлдэл үзүүлдэг. Иймд орон нутгийн удирдлагууд нь төрийн үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр ИНБ-тай гэрээллэдэг ба ИНБ-уудыг анхан шатанд иргэд, олон нийттэй илүү ойр ажиллаж, орон нутгийн хэрэгцээг сайн ойлгож, илүү хэмнэлттэй, уян хатан байдаг гэж үздэг. Энэ нь мэргэжлийн ур чадвартай ИНБ-уудыг төрөөс зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх боломжийг олгодог. Зарим тохиолдолд ИНБ, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж Засгийн газрын бодлого боловсруулах, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахдаа оролцуулдаг.

Төвлөрлийг сааруулах хүчин чармайлт

ИНБ, иргэдийг бодлогын хэлэлцүүлэгт болон мониторингийн үйл явцад оролцуулах нь сайн засаглал, ил тод, хариуцлагатай байдлыг дэмжихэд чухал ач холбогдолтой. Тиймээс ИНБ-уудын төвлөрлийг сааруулах нь орон нутгийн иргэдийг чадавхжуулдаг ба шийдвэр гаргах үйл явцад илүү хяналт тавих боломжийг олгодог. Энэ нь иргэдийг өөрсдийн амьдралд нөлөөлөх асуудлуудад оролцох, үүрэг хариуцлагаа ухамсарлах боломжийг олгодог. Үүнээс гадна орон нутгийн хөгжил, төрийн үйлчилгээнд дунд болон анхан шатны засаг захиргааны байгууллагуудын гүйцэтгэх үүргийг онцолж байсан. Монгол Улс төвлөрлийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Гэхдээ нөгөө талдаа төрийн албан хаагчдыг сургах чиглэлээ иргэд, ИНБ-уудад зориулсан ижил төстэй хөтөлбөрүүдтэй уялдуулахгүй байна. Улмаар энэ нь төрийн албан хаагчид бодлогын яриа хэлэлцээр, хяналт тавихад чухал ач холбогдол бүхий хүмүүсийг оролцуулах боломжийг багасгаж байна.

Мэдээлэл түгээх

Иргэдийн оролцоо ба бодлогын хэрэгжилтийн хоорондын уялдааг сайжруулахад орон нутгийн түвшинд мэдээллийг сайтар түгээх шаардлагатайг судалгаанд оролцогч ИНБ болон төрийн байгууллагууд онцолж байв. Харин иргэд, ИНБ-ууд найдвартай мэдээлэл авах боломжгүй байх нь олонтаа. Энэ нь тодорхой сэдэвт хүрээндээ мэдээлэл солилцоход ИНБ-уудад дөхөм үзүүлэх шаардлагатайг онцолж байна.

Цахим ардчиллын төлөв байдал

Монгол улс 'Дижитал үндэстэн' рүү шилжиж байгаа нь интернетийн өргөн холболт (дата хэрэглээний 80%, 2.6 сая хэрэглэгч), утасны хүртээмж 96% байгаа зэрэг нь томоохон боломжийг олгож байна. Цахим ардчиллын санаачилгууд нь олон нийтийн оролцоо, ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, өргөдөл, гомдол, зөвлөмжийг цахим хэлбэрээр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Мөн дижитал платформыг алслагдсан болон хөдөө орон нутгийн бүх иргэдэд хүртээмжтэй байлгахад зорьж байна. Энэ нь дижитал ялгааг арилгаж, өргөн хүрээний хүмүүст төрийн үйлчилгээнд хамрагдах, ардчилсан үйл явцад оролцох боломжийг олгох юм. Монгол Улсад ашиглагдаж буй цахим платформууд төрийн үйлчилгээ, олон нийтийн оролцооны олон талт үйл ажиллагааг хангадаг. "Ухаалаг Улаанбаатар" аппликейшн нь хууль тогтоох үйл явцад иргэдийн оролцоог хангах d-parliament-аас эхлээд 11-11 цахим хуудаснаас өргөдөл, гомдол гаргах хүртэл хотын талаарх олон төрлийн мэдээллийг өгдөг. Нэмж дурдахад, ХАСХОМ гэх мэт нээлттэй мэдээллийн платформууд авлигатай холбоотой мэдээллийг харуулдаг. Төрийн тусгайлсан цахим хуудсууд нь төрийн худалдан авалт, төсвийн ил тод байдал, сонгуулийн мэдээлэл, ашиглалтын лиценз зэрэгтэй холбоотой. Цахим Монгол нь олон талт байдлыг үл харгалзан эдгээр үйлчилгээг төрийн үйл ажиллагааны үр ашиг, ил тод байдал, үр ашгийг дээшлүүлэх нэгдсэн платформ болгон нэгтгэхийг зорьж байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9-ийн 391 дүгээр зүйлд цахим платформуор дамжуулан иргэдийн оролцоог хуульчлан заасан байдаг ч ИНБ-ууд, цахим оролцооны үйл явц болон бодит шийдвэр гаргалт хоёрын хооронд зөрөө их байгааг онцолсон юм. Шийдвэр гаргахад олон нийтийн сүлжээ, ялангуяа Facebook-ийн нөлөөлөл их байдаг тул засгийн газар цахим хэрэглүүрийг дутуу ашигладаг гэсэн шүүмжлэл бий.

ИНБ-ын оролцоонд тулгарч буй саад бэрхшээл

Техникийн саад бэрхшээл:

ИНБ-ын 40% нь төрийн байгууллагууд болон ИНБ-ын хоорондын итгэлцлийг маш муу гэж үнэлсэн нь ил тод байдлын асуудал, мэдээлэл түгээх хангалтгүй байдал, засгийн газар ИНБ-ыг шийдвэр гаргахад оролцуулахад заримдаа дурамжхан байдаг нь хардлага төрүүлж, хамтын ажиллагаанд саад болдогтой холбоотой. Төрийн байгууллагууд ИНБ-ыг эрх мэдлээ сорьж байна гэж ойлгодог бол ИНБ-ууд улс төрийн нөлөөллөөс болгоомжилж, засгийн газар тодорхой ИНБ-уудаар дамжуулан ажиллах хандлагатай байдаг тул харилцан үл итгэх байдал бас бий. ИНБ-ын хүчин чармайлтыг дахин давтан хийж, засгийн газар тэдний санаа бодлыг урьдчилан асуухгүйгээр хэрэгжүүлдэг нь харилцааг улам хурцатгах талтай байна. Мөн ИНБ-ууд хоорондоо мэдээлэл солилцож, үр ашигтай харилцах боломж хомс байгаа нь ажил давхцахад хүргэдэг. Бодлогын дүн шинжилгээ, нөлөөллийн мэдлэг дутмаг, санхүүгийн бэрхшээл, хүний нөөцийн хязгаарлагдмал байдал, байнгын оффисын хомсдол зэрэг нь ИНБ-уудын бодлогын яриа хэлэлцээнд үр дүнтэй оролцоход саад болж байна.

Тухайлбал НХХЯ-наас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөх байгууллагуудыг сонгож гэрээлэн ажилладаг ч мэргэжил арга зүйгээр хангадаггүй, бас тэр шалгуурыг хангах байгууллагууд ховор байдаг. Мөн шалгуурыг даваад гэрээлэн гүйцэтгэх боллоо гэхэд өөрсдөөсөө нөөц гаргаж үйлчилгээ эхлээд үзүүлдэг болсон нь бэрхшээл учруулдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын чадавхи сул хэвээр байх нөхцлийг үүсгэж байна.

Бүтцийн саад бэрхшээл:

ИНБ-ын төрийн оролцоонд тулгарч буй бэрхшээлүүд нь санхүүжилт хангалтгүй, амжилтын тодорхой хэмжүүр дутмаг зэргээс үүдэлтэй бөгөөд цахимаар авсан ИНБ-ын судалгааны үр дүнгээс харвал НҮБ-ын агентлаг (48%), Дэлхийн банк (28%), АНУ-ын засгийн газрын агентлагууд (18%), Канадын дэлхийн асуудал (13%), ЕХ-ны комиссууд болон ЕХ-ны харьяа агентлагууд (10%) зэрэг хандивлагч байгууллагуудад санхүүжилт авахаар санал явуулж чадсан нийт байгууллага дөнгөж 55% байна. Түүнээс гадна төрийн албан хаагчдын халаа сэлгээ нь ихэвчлэн сонгуулиас үүдэлтэй байдаг нь хамтын ажиллагаанд саад учруулж байна. Цаашилбал, төрийн албан хаагчдын ой санамжийг тооцоолоогүй орон тооны цомхотгол нь үр ашиггүй, хариуцлага тодорхойгүй байдалд хүргэж байна. Тухайлбал, агаарын чанарыг зөвхөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцдаг байсан нь зарим яамд чимээгүй хандахад хүргэж байна. Бодлогын түвшинд хариуцлагын энэхүү тодорхой бус байдал нь гол асуудлуудын эрэмбийг алдагдуулж, ахиц дэвшилд саад учруулж байна.

Улс төрийн саад бэрхшээл:

Улс төрийн саад бэрхшээлүүд нь ИНБ-ын оролцоонд нөлөөлж байна. Одоо тулгарч буй нэг томоохон асуудал нь төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны орон зай багасч байгаа явдал юм. Тухайлбал ИНБ-уудыг "холбоо" эсвэл "сан" гэж ангилж, үйл ажиллагааг нь хумих, дарах бодитой эрсдэл байна. Civicus Монголын иргэний орон зайг "хумигдсан" гэж дүгнэж, 100 онооноос 61 оноо өгсөн нь, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөөг зөрчсөн байгаатай холбоотой гэжээ. Нэмж дурдахад, засгийн газрын зүгээс санал хүсэлт хүлээн авсан гэж мэдэгдсэн ч хариу үйлдэл үзүүлэхгүй байх нь элбэг байдаг тул санал хүсэлтийн эргэх холбоо алдагдаж, үр дүнтэй харилцаа холбоо саадтай байдаг. Тухайлбал хуулийн ажлын хэсэг дээр ИНБ-ын саналыг авдаг ч нэг ч саналыг ажлын хэсэг дээр уншиж, танилцуулж, тусгахгүй байх явдал түгээмэл.

Дижитал саад бэрхшээл:

Монгол улс дижитал өөрчлөлтийн аяндаа хэд хэдэн сорилттой тулгарч байна. Ойролцоогоор манай оронд 2.2 сая хүн (нийт хүн амын гуравны хоёр) Facebook-ийг идэвхтэй ашиглаж, мобайл үйлчилгээнд холбогдсон байхад интернэтийн үнэ нь бага орлоготой өрхүүдэд саад болж байна. Энэхүү интернэтийн хүртээмжгүй нь дижитал шилжилтийн ерөнхий үйл явцад саад учруулж байна. Түүнчлэн Монгол Улсын иргэд цахим оролцооны хэрэгслийн талаар төдийлөн сайн мэдээлэлгүй байгаа нь 11-11 гэх мэт платформыг бүтээлч оролцоо гэхээсээ илүүтэй хувийн хүсэлтэд зориулж үр дүн багатай ашиглахад хүргэж байна. МХХТ-ийн ур чадвар хангалтгүй, ИНБ-ын дижитал аюулгүй байдлын ур чадвар бага, дижитал өөрчлөлтийн талаарх ойлголт хязгаарлагдмал зэрэг асуудлууд ахиц дэвшилд саад болж байна. Нэмж дурдахад, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст одоо байгаа дижитал програмуудыг ашиглах боломж хязгаарлагдмал байдаг. Ижил төрлийн онлайн платформууд олширч байгаа нь асуудлыг улам хүндрүүлж, найдвартай мэдээлэл олоход хүндрэл учруулж байна. Төрөл бүрийн цахим платформтой хэдий ч олон монголчууд Facebook, Twitter зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд ихээхэн найдаж, ташаа мэдээлэл түгээж байна. COVID-19 тахлын үеэр ташаа мэдээлэл ноцтой асуудал болсон ба, судалгаанд оролцсон ИНБ-ын 93% нь найдвартай мэдээллийн хүртээмжийг муу гэж үнэлэв.

Бодлогын нөлөөлөлд ИНБ-ын оролцоог цаашид дэмжиж ажиллахад дөхөм болохуйц санаачлага

Судалгааны үр дүнд Иргэний нийгмийн оролцогчид, засгийн газар, байгууллагуудын хандивлагчдад зориулсан дараах зөвлөмжийг гаргалаа.

Иргэний нийгмийн байгууллагууд

Засгийн газартай үр дүнтэй харилцахын тулд ИНБ-ууд бодлого боловсруулах түвшний оролцогч талуудтай идэвхтэй хамтын ажиллагааг бий болгосон сайн стратегитай байх хэрэгтэй. Энэхүү хамтын ажиллагаа нь бодлого боловсруулагчидтай мэдээлэлтэй, оновчтой хэлэлцүүлэг өрнүүлэхийн тулд баттай өгөгдөлд тулгуурласан, нотолгоонд суурилсан байх ёстой. Итгэлцлийг бий болгох нь бодлогын яриа хэлэлцээрт нэн чухал бөгөөд энэ нь ил тод байдал, хамтын ажиллагааг дэмжихээс гадна ИНБ-уудад шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх боломжийг нэлээд олгодог.

Салбарын хүрээнд хамтын ажиллагааны арга барилыг сонгохдоо ИНБ-ууд бодлогод хамтын нөлөө үзүүлэх, эерэг өөрчлөлтийг авчрах зорилгоор ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай сүлжээ, эвсэл байгуулж ажиллаж байгаа нь үр дүнтэй байна. Байгаль орчин, засаглалын чиглэлээр ажиллаж байгаа ТББ-уудын эвсэл, сүлжээ идэвхитэй сайн ажилладаг хэдий ч хүүхэд хамгаалал, эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа ТББ-ууд эвсэл, сүлжээ болж ажиллахдаа сул байдаг тул үүн дээр анхаарах шаардлагатай.

ИНБ-уудхийнгээ суралцаад буюу одоо идэвхитэй байгаа цахим платформуудыг ашиглаад бодлого боловсруулахад оролцох боломжоо нэмэгдүүлж, хаанаа доголдол зөрүү үүсээд байна гэдгийг нь харилцан мэдээлээд сайжруулаад явах нь чухал байна. Тиймээс ИНБ-ын чадавхийг бэхжүүлэх нь нэн чухал бөгөөд сургалт, сурталчилгаа, судалгаа, харилцаа холбоо, хамтын ажиллагааны хүрээнд анхаарах шаардлагатай байгаа хоцрогдол, сургалтын хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох шаардлагатай. Нөгөө талаас цахим оролцоог сайжруулахын тулд төрийн байгууллагууд дижитал платформуор орж ирэх ИНБ-ын дуу хоолойг анхаарч үзэх нь чухал юм. Үүний тулд ИНБ-ууд болон иргэдийг цахим оролцооны хэрэгслийг ашиглах талаар мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ухуулга сурталчилгаа хийх шаардлагатай. Дижитал саад тотгорыг багасгахын тулд интернет холболтын дэд бүтцэд ялангуяа зорилтот бүлгүүдэд хөрөнгө оруулалт хийх, дижитал

аюулгүй байдлын ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнээс гадна үйл ажиллагаагаараа дамжуулан одоогийн цахим платформуудыг хэрэглэгчдэд ээлтэй байдлыг сайжруулах, хялбарчлахад байнга анхаарах хэрэгтэй.

Засгийн газар, төрийн байгууллагууд

Олон улсын зөвлөмжүүдэд засаглал, иргэдийн оролцоог сайжруулахын тулд төр, иргэний нийгмийн байгууллагын хоорондох хамтын ажиллагаа болон төрийн ил тод, хүртээмжтэй байдлыг чухал болохыг онцолжээ. Тогтвортой харилцаа холбоо нь олон нийтийн төлөөллийг дэмжсэн хууль эрх зүйн орчны бодлогын баримт бичгийг боловсруулахад ИНБ-ын оролцоог сурталчлахын зэрэгцээ талуудын дунд итгэлцлийг бий болгох давуу талтай. Ялангуяа нийслэлээс бусад аймгуудын чадавхийг бэхжүүлэхэд анхаарч байгаа нь илүү өргөн хүрээтэй оролцоо шаардлагатайг харуулж байна. Ил тод байдлыг хангах үүднээс иргэд, ИНБ-уудыг оролцуулсан үр дүнтэй саналын механизм бий болгож, хууль эрх зүйн орчны шинэчлэл, санхүүжилтын механизмаар дамжуулан орон нутгийн ИНБ-уудыг чадавхжуулах төвлөрсөн бус арга барил шаардлагатай байна. Засаглалын шилжилтийг жигд хүртээмжтэй явуулахыг онцгой анхаарахаас гадна, төрийн байгууллагуудын тогтвортой, олон талт байдлыг хадгалахын тулд мерит зарчимд суурилсан ажлын хуваарилалт, баримтжуулалт, хамтын ажиллагааг чухалчлах хэрэгтэй. Тухайлбал бодлогын орчинд ямар асуудал дээр ТББ -ууд заавал оролцох вэ? хаана хянах вэ? юуг засах вэ? гэдэг дээр ТББ-ын эрх үүргийг нарийн заасан байх шаардлагатай. Ингэснээр хууль эрх зүйн хүрээнд ИНБ-уудын оролцоог хангах механизм бүрдэх юм.

Хандивлагч/ санхүүжүүлэгч байгууллагууд

Байгууллагын санхүүжүүлэгчид ИНБ-уудын бодлогын нөлөөлөл хийх, ухуулга сурталчилгааны компани ажлыг санхүүжүүлэх замаар тэдний нөлөөллийг дэмжих чухал үүрэгтэй. Үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд хандивлагчид төвлөрлийг сааруулах санаачилгуудын үр дүнг үнэлэх хяналт, үнэлгээний механизмыг хэрэгжүүлэх шаардлагатай. Орон нутгийн төрийн байгууллагууд, сургалтын ажилтнууд, ИНБ-уудын чадавхийг сайжруулах төслүүдийг эрэмбэлснээр санхүүгийн удирдлага, үйлчилгээний хүртээмжийг анхан шатны түвшинд сайжруулахад маш чухал юм.

Бодит байдалд ИНБ-ууд санхүүжилтээ дагаж ажилладаг ч санхүүжүүлэгч байгууллага болон ИНБ нь эн тэнцүү хамтын ажиллагаатай байх нь нэн чухал юм. Мөн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад илүү боломж байдаг, тэр хэрээрээ хөгжиж байдаг ч бодлого шийдвэрт нөлөөлдөг, нөлөөллийн ажил хийдэг ТББ-уудад боломж хязгаарлагдмал байдаг. Үүнээс гадна, аливаа олон улсын байгууллагууд төслийн дизайныг гаргахдаа ИНБ-уудыг маш сайн оролцуулж байх шаардлагатай. Мөн санхүүжүүлэх гэж буй төслийнхөө шаардлагад ИНБ-уудын оролцоог хангах талаар аль болох оруулах хэрэгтэй. Олон улсын төслүүдэд удирдлагын зөвлөл гэх мэтийг байгуулдаг ч түүндээ ИНБ-уудын оролцоог шаардах нь үр дүнтэй хэрэгжилтийн суурь болох юм.

Төгсгөлд нь:

Монгол Улсын өнөөгийн байдлыг тоймлон харвал нээлттэй, ил тод засаглалын зарчмын дагуу төр болон иргэний нийгмийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр аль аль талаас тодорхой хэмжээнд хүчин чармайлт гаргасаар байна. Хэдий тийм ч бодит байдал дээр төр, ИНБ-ууд нэгдэж чадахгүй байх техникийн, бүтцийн, улс төрийн, болон дижитал саад бэрхшээлүүд оршсоор байна. Төрийн байгууллагууд аливаа бодлого боловсруулах үйл явцад ИНБ-ын саналыг авдаг, аливаа асуудлаар хамтран хэлэлцүүлэг явуулдаг боловч эцсийн мөчид саналууд нь ордоггүй, тусахгүй байх явдал түгээмэл байгаа нь энэ талаар нарийвчлан судалж, нийт ирсэн саналын хэдэн хувийг нь шийдвэр гаргалтад тусгасан байдагийг судлах хэрэгтэй байгааг харуулж байна. Нөгөө талаас ИНБ-ууд өөр хоорондоо хамтран ажилласнаар илүү хүчтэй хэлэлцүүлэг өрнүүлж, дуу хоолойгоо нэгтгэх нь чухал харагдаж байна. Үүн дээр хэд хэдэн сайн жишиг ч бийг уг судалгаанд дурьдсан. Ийнхүү оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах нь нөөц, туршлагаа нэгтгэх замаар аливаа шийдвэрийн үр ашгийг дээшлүүлж, үйл ажиллагааны давхардлаас сэргийлэх боломжийг бүрдүүлнэ. Төгсгөлд нь төр ба иргэний нийгмийн уялдаа холбоог амжилттай болгосноор үр дүнтэй хамтын ажиллагаа бий болж, Монголын нийгмийн сайн сайхан байдал, цаашдын хөгжил дэвшилд ихээхэн түлхэц болох билээ.

